

## МОНГОЛ ДАХЬ ЗҮҮН ӨМНӨД АЗИ СУДЛАЛЫН ТОЙМ

*С.Дашцэвэл\**

Энэтхэг, Хятадын соёлын нөлөө гүнзгий туссан Азийн эх газрын зүүн өмнөд хормой түүнийг эмжсэн өмнөд далайн арлуудад орших бүлэг улсыг Зүүн Өмнөд Азийн улс орнууд хэмээн нэрлэнэ. Энэ бүс нутгийн улс орнууд байгаль цаг уурын ижил нөхцөлтэй түүнд тохирсон ахуй соёлын нийтлэг шинж төрхтэй ажээ.

Зүүн Өмнөд Азийн судлал нилээд эрт үеэс эхэлсэн. Юуны өмнө өрнө дорнын далайчид шашны элч нар энэ бүс нутгийнхны тухай тэмдэглэж үлдээсэн зүйл бишгүй бий. Тухайлбал XIII зуунд Марко Поло, Chu Daguang, Ibn Batutah нар Зүүн Өмнөд Азиар аялсан тэмдэглэлээ үлдээжээ. ХҮI зуунаас энэ бүс нутгийн газар зүйн байршил ялангуяа Зүүн Азийг Араб, Газрын дундад тэнгис, Европтой холбосон далай тэнгисийн зам газрын хувьд өрнө дахины анхаарлыг татжээ. XVIII зуунаас Зүүн Өмнөд Азийн угсаатны түүх соёлыг өрнөдийнхөн багагүй судласан байна. Өнгөрсөн зууны дунд үеэс бүс нутгийнхан дэлхийн бодлогод хүчтэй татагдан орсон учир Их гүрнүүдийн улс төр, геополитикийн судалгаанд илүү өртөгдөх болсон юм.

Зүүн Өмнөд Ази судлалд дэлхийн томоохон эрдэмтэд тухайлбал D.G.E. Hall, Georges Coedes, Pierre Gourou, Paul Pelliot, H. Maspero, A. Губер, D.R. Sardesai нар үлэмж хувь нэмрээ оруулсан билээ. Мөн XX зуунаас тус бүс нутагт үндэсний сэргэн мандал өрнөсөнтэй зэрэгцэн үндэсний сэхээтэн ба эрдэм судалгааны газрууд бий болж бүс нутгийнхаа түүх соёл, эдийн засаг, улс төр-аюулгүйн асуудлыг эрчимтэй судалж эхэлжээ.

Монголчууд Зүүн Өмнөд Азийнхныг 800-аад жилийн өмнөөс мэддэг байлаа. XII зууны дундуур Ху нарын элч анх Вьетнамын хааны ордонд очсон тухай ХҮI зууны Вьетнамын түүхэн сурвалжид тэмдэглэсэн байдаг.<sup>1</sup>

Монголын дараагийн элч 1258 онд очсон бөгөөд түүнээс хойш 100-аад жил энэ бүс нутгийн улс орнуудтай монголчуудын холбоо харилцаа тасраагүй билээ. Харин Монголын эзэнт гүрэн задарч тэдний гадаад харилцаа хумигдаж улмаар Манжийн Чин улсын хараат дагуул орон болсон хийгээд Зүүн Өмнөд Азийнхан европын эзэмшил болж улс төрийн бүрэн эрхээ алдсан зэрэг шалтгаанаас хоёр талын харилцаа удтал тасарсан ажгуу. Гэвч өнгөрсөн зууны эхнээс үндэсний тусгаар байдлын төлөөх тэмцэл дэлхийг донсолгож Монгол болон Зүүн Өмнөд Азийнхан тусгаар тогтнолоо тунхагласнаас хойш сая албан ёсны харилцаа сэргэв. XX зууны 50-60-аад оноос Монгол Улс Зүүн Өмнөд Азийн Вьетнам, Лаос, Индонез, Бирм зэрэг улс оронтой дипломат харилцаа тогтоож улс төр эдийн засаг,

\* С.Дашцэвэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

соёлын салбарт харилцаа эхлэв. Энэ үед Зүүн Өмнөд Азийн зарим орны тухай Монгол Улсын хэвлэлд мэдээлэл сурталчилгааны шинжтэй өгүүлэл нийтлэл мэр сэр бичигдэж, уран зохиолын зарим нэг бүтээл орчуулагдан хэвлэгдэж байснаас цааш хэтэрсэнгүй. Гэвч 60-аад оны сүүлчээр Монгол Улсын ШУА-д гадаад орон судлалын байгууллагын үндэс суурь (1968 онд Ази Африкийн хэлтэс, хожим нь 1976 онд Дорно дахины судлалын хүрээлэн болж өргөжсөн) тавигдаж Ази дорно дахины орнуудын тухай судлах болсон билээ. Энэ үеэс Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн улс орнууд судалгаанд хамрагдах болов.

Тухайн үед хүйтэн дайны уур амьсгал нэн гүнзгийрч Зүүн Өмнөд Азийн нэг хэсэг болох Энэтхэг-Хятадын хойгт АНУ-ын дайны ажиллагаа өргөжиж байсан тул улс төрийн шинжтэй судалгаа зонхилж байв. Тэр үед Зүүн Өмнөд Азийн асуудал нэн эдрээтэй байсан бөгөөд АНУ-ын дайны ажиллагаа Хятад, Оросын эрх ашигтай сүлжилдэн тус бүс нутаг чухамдаа их гүрнүүдийн бодлого стратегийн гол цэг болж байсан билээ. Иймд Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ сэдвээр өргөн мэдээлэл цацаж байсан төдийгүй манай улсын гадаад харилцааны эрдэмтэн мэргэжилтнүүд уг асуудалд анхаарлаа хандуулахгүй байж чадаагүй юм. Тухайлбал доктор Ш.Сандаг, Н.Ишжамц, Ц.Батбаяр, С.Дашцэвэл нар Ази, Номхон далайн олон улсын байдал түүний дотор Энэтхэг-Хятадын хойг дахь дайн түүний эргэн тойрны асуудалд дүн шинжилгээ хийж түгшүүрт байдлыг намжаах энх амгалан байдлыг тогтоох талаар өөрийн санал дүгнэлтийг илэрхийлсэн судалгааны өгүүлэл илтгэл хамтын бүтээл олныг туурвисан юм.<sup>2</sup>

Тэр үеийн улс төр, дайн энхийн талаарх судалгаа хэдийгээр хүйтэн дайны үеийн үзэл сурталд хэт хөтлөгдсөн зарим талаар өрөөсгөл буюу нэг талыг барьсан шинжтэй байсан ч түүхэн чухал үлэмжхэн баримт материалыг судалгааны эргэлтэнд оруулж байсан төдийгүй зарим дүгнэлт санал нь тухайн үеийн бодит нөхцлөөс урган гарч байсныг үгүйсгэх аргагүй юм. Ялангуяа БНСВУ-ын Ази, Номхон далайн хүрээлэнгийн эрдэмтэдтэй хамтран бичсэн “Өнөөгийн Ази: дайн энхийн асуудал” хамтын бүтээл нь Зүүн болон Зүүн өмнөд Ази дахь их гүрнүүдийн бодлого ба олон улсын харилцааны чухал асуудлуудыг хөндөж тэнд өрнөсөн дайн энхийн асуудлыг эрдэм шинжилгээний үүднээс анх дүгнэсэн бүтээл байлаа.<sup>3</sup>

Мөн үед манай орны нийгмийн шинжлэх ухааны салбар капиталист бус хөгжлийн тухай, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний тухай, хөгжиж буй орнуудын дунд өрнөсөн улс төр эдийн засгийн өргөн хүрээтэй бусад асуудалд анхаарлаа хандуулж байсан тул тэрхүү судалгааны хүрээнд Зүүн Өмнөд Азийн орнууд ч хамрагдаж байлаа. Тухайлбал Доктор Н.Дангаасүрэн, Л.Хайсандай, Х.Дашдондов нар Ази, Африкийн хөгжиж

буй орнуудыг судлах дашрамдаа Зүүн Өмнөд Азийн хөгжиж байгаа зарим орны эдийн засаг улс төрийн хандлагыг хамруулан судласан нь бий.

1980-аад оны сүүлчээс Зүүн Өмнөд Азийн эдийн засгийг түлхүү сонирхож Азийн бар улсуудын хөгжлийн туршлага,<sup>4</sup> 1990-ээд оноос Ази тив, түүний салбар бүс нутгуудын хамтын ажиллагаа, түүнд Монгол Улсын оролцооны тухай, мөн Зүүн Өмнөд Азийн орнуудтай Монгол Улс хамтран ажиллаж байгаа байдал түүний хэтийн төлвийн талаарх асуудалд эрдэмтэд түлхүү анхаарч судлах болсон<sup>5</sup> нь орчин үеийн даяаршлын болон эдийн засгийн интеграцчилалын нөхцөл дэх Монгол Улсын нээлттэй гадаад бодлоготой нягт холбоотой байв.

Монгол Улс нь Зүүн Хойт Ази, Төв Азийн хамтын ажиллагаанд оролцохоос гадна Ази, Номхон далайн бүсэд хамгийн эрчимтэй хөгжиж байгаа эдийн засгийн бүлэглэл болох Зүүн Өмнөд Ази (ASEAN)-ийн хамтын ажиллагаанд оролцох нөхцөл бололцооны тухай сүүлийн үед хэд хэдэн судалгаа гарсан<sup>6</sup> бөгөөд Монгол Улс ASEAN-ны Аюулгүйн Чуулга буюу ARF-д 1990-ээд онд элсч улмаар ASEAN-ны “Treaty of Amity and Cooperation in Southeast Asia” буюу Найрамдал хамтын ажиллагааны Гэрээнд 2005 онд элссэн зэрэг нь Монгол ба ASEAN-ны хамтын ажиллагаа алхам алхамаар өргөжих нөхцлийг бий болгов. Сүүлийн үед ASEAN+3 хэмээх хамтын ажиллагааны өргөн хүрээтэй бүс бий болох хандлага хүчээ авч байгаа нь Монгол Улсын анхаарлыг зүй ёсоор татах болов. Иймд Зүүн Өмнөд Азийн худалдааны чөлөөт бүс (AFTA) болон ASEAN+3-ын үйл явцыг нарийвчлан судалж тухайн бүсийн эдийн засгийн интеграцид оролцох Монгол Улсын боломжийн талаарх монголын эрдэмтэн мэргэжилтнүүдийн судалгаа практикийн чухал ач холбогдолтой юм.

Эдгээр судалгаанаас гадна Монгол ба Зүүн Өмнөд Азийн орнуудын эрт эдүгээгийн харилцааг судалсан бүтээл хэд хэд гарсан бөгөөд Монголын түүхчдийн бүтээлд дашрамд дурдагдсан зүйл ч мөн цөөнгүй байна.<sup>7</sup> Цаашид Монгол ба Зүүн Өмнөд Азийн эртний харилцааг гүнзгийрүүлэн судлах мөн түүний орчин үеийн олон талт харилцааг нэгтгэн дүгнэх ажил эзнээ хүлээж байна.

### **Монгол дахь Зүүн Өмнөд Азийн судлалд холбогдох бүтээлийн жагсаалт**

1. Д.Баасанхүү. БНСВУ бол Зүүн Өмнөд Ази дахь манай найдвартай түнш мөн. “Монгол-Вьетнамын харилцаа-50 жил, УБ 2005 он”
2. Ц.Баатар. Кампучи нийгмийн хөгжил дэвшлийн замаар. “ДИСА” сэтгүүл, УБ 1982, №2
3. Ц.Батбаяр. АНУ-ын Азийн бодлого. “Дорно-Өрнө” сэтгүүл УБ, 1991 №4

4. Ц.Батбаяр. Эдийн засгийг либеральчлах Индонезийн туршлага. “Дорно-Өрнө” сэтгүүл УБ, №3-4
5. Д.Баярхүү. Камбожийн хувьсгалын үйл явц. “ДДСА” сэтгүүл, УБ 1984, №1
6. Д.Баярхүү. “Монгол Улсаас АРФ, АСЕАН, АСД-д оролцох бодлогын тухайд. “Олон улс судлал” сэтгүүл, УБ 2004, №4
7. Д.Галсандорж, Х.Буд. Монгол-Вьетнам, Монгол-Лаос, Монгол-Камбожийн эдийн засгийн харилцаа. “Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаа” УБ, 2001 он
8. Б.Гантуяа. “Монгол-Вьетнам хоёр улсын найрамдал хамтын ажиллагаа 60 жил”. УБ, 2007 он
9. А.Дамдинсүрэн. Бирмийн холбооны улс. “Хөрөнгөтний бус хөгжлийн замаар замнаж буй Ази, Африкийн зарим орон”, УБ 1970 он
10. Н.Дангаасүрэн. Гурав дахь ертөнц аж үйлдвэржих асуудал, “ШУА-ны Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг”, УБ 1973 он
11. Н.Дангаасүрэн. “Хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн тусгаар тогтнол ба капиталист биш өөрчлөн байгуулалт”. УБ 1979 он
12. Х.Дашдондов. “Пути и перспективы общественного прогресс развивающихся старанах”. Москва 1990 г, ч. 1
13. Х.Дашдондов. Проблем развития “третьего мира” в новой мировой ситуации. Москва 1989 г.
14. С.Дашцэвэл. Вьетнамын яруу найрагч То Хыугийн уран бүтээл. “Цус цэцэг” номонд УБ, 1976 он
15. С.Дашцэвэл. Монгол-Вьетнамын аман зохиолын холбогдол. “Вьетнам ардын үлгэр домгийн оршил” УБ, 1976 он
16. С.Дашцэвэл. Энэтхэг-Хятадын хойгийн ард түмний ялалт. “ДДСА” 1978, №1
17. С.Дашцэвэл. Зүүн Өмнөд Азийн сүүлийн үеийн байдал: Тогтвортой байдлыг хангах шинэ алхам. “ДДСА” 1987, №2
18. С.Дашцэвэл. Хятадын удирдлагаас БНСВУ-ын эсрэг явуулж ирсэн бодлого үйл ажиллагаа. “ДДСА” УБ 1979, №2
19. С.Дашцэвэл. Зүүн Өмнөд Ази дахь түгшүүртэй байдлын нэг голомт. “ДДСА” УБ, 1986 он №1
20. С.Дашцэвэл. Монголын түүхэнд холбогдох Вьетнамын сурвалж бичгүүд. “ДДСА” 1979, №1
21. С.Дашцэвэл. Вьетнам дахь Монголын түүхийн зарим мэдээ. “ДДСА” 1980, №3
22. С.Дашцэвэл. К вопросу о современном этапе Вьетнамо-Китайских отношении Сборник “Вопросы истории и филологии стран Азии, Африки и Латинской Америки” Москва 1985
23. С.Дашцэвэл. Вьетнамо-Китайские отношения 60-х в сб. материалы XIX научных теоретических конференции молодых ученых и специалистов. Киев, 1985

24. С.Дашцэвэл. Хятад-Вьетнамын тулгамдсан зарим асуудал. “ДДСА” 1988 он
25. С.Дашцэвэл. 13-р зууны Монгол, Вьетнамын элчин харилцааны түүхээс. “ДДСА” 1990 №1
26. С.Дашцэвэл. 13-р зууны Монгол-Тайландын харилцааны түүх. “Дорно Өрнө” УБ 1995 №1,2
27. С.Дашцэвэл. Хо Ши Мин Монголын хүндтэй бөгөөд дотны хүн. “Шоронд бичсэн тэмдэглэл” УБ, 2000 он
28. С.Дашцэвэл. 1945 оны Вьетнамын хувьсгал түүний олон улсын ач холбогдол. “Вьетнам 21-р зуун” сэдэвт олон улсын бага хурал. Ханой, 2000 он
29. С.Дашцэвэл, Ле Ванзыонг. Вьетнам дахь Монгол судлал. “Залуу монгол судлаачдын хурал” 1990 он
30. С.Дашцэвэл. Вьетнам дахь Монгол судлалын ном зүй. Bibliography of Mongolian studies УБ, 1996
31. С.Дашцэвэл. БНСВУ дахь эдийн засгийн шинэчлэл. “ДДСА” 1989 он, №1
32. С.Дашцэвэл. БНСВУ-ын хөдөө аж ахуйн шинэчлэл. “ДДСА” 1991 он, №3
33. С.Дашцэвэл. Зүүн Өмнөд Азийн аюулгүй байдлын асуудал. “Монгол-Америкийн бага хурал” УБ, 1991
34. С.Дашцэвэл. АСЕАН элсэх гол зам бол Балийн гэрээ. “Дорно Өрнө” сэтгүүл УБ, 1995 он
35. С.Дашцэвэл. Зүүн Өмнөд Азийн орнуудын эдийн засгийн хөгжлийн зарим онцлог ба өнөөгийн төлөв. Лавлагааны товхимол УБ 2004 он
36. С.Дашцэвэл. 90-ээд оны Монгол-Вьетнамын харилцаа: Өнөө, ирээдүй. “Дорно Өрнө” сэтгүүл, 1994 №1
37. С.Дашцэвэл. Зүүн Ази дахь шинэ регионализм “АСЕАН+3” ба Монгол Улс. “Олон улс судлал” сэтгүүл УБ, 2003 №3
38. С.Дашцэвэл. АСЕАН-ы аюулгүй чуулга ба Монгол Улс. “Олон улс судлал” сэтгүүл УБ, 2003 он
39. С.Дашцэвэл. Бүс нутгийн эдийн засгийн интеграцийн зарим асуудал. “Олон улс судлал” сэтгүүл УБ, 2003 он №4
40. С.Дашцэвэл. АСЕАН түүний эдийн засгийн интеграцийн туршлага, сургамж. “Олон улс судлал” сэтгүүл УБ, 2004 он №2
41. С.Дашцэвэл. “Зүүн Өмнөд Азийн хөгжлийн хандлага, интеграци: Монгол Улсын бодлого чиглэл”. УБ 2005 он
42. С.Дашцэвэл. Юань улс Зүүн Өмнөд Азийн орнуудтай харилцсан нь. “Монголын эзэнт гүрний гадаад харилцаа” /ред. Н.Ишжамц, С.Дашцэвэл/ УБ 1995 он
43. С.Дашцэвэл. Хүйтэн дайны дараа Зүүн Өмнөд Ази ба Монгол Улс. “Ази тив түүний салбар бүс нутгуудын хамтын ажиллагаанд Монгол Улсын оролцоо хэтийн төлөв” /ред. Ц.Батбаяр, С.Дашцэвэл/ УБ 1997 он

44. С.Дашцэвэл. Зүүн Өмнөд Азийн санхүүгийн хямрал, түүний шалтгаан мөн чанар. “Дорно Өрнө” сэтгүүл 1999, №1
45. С.Дашцэвэл. Зүүн Өмнөд Ази ба Монгол (түүх угсаатны соёлын харилцаа). “Олон улс судлал”, УБ, 2008
46. С.Дашцэвэл. “АСЕАН-ы интеграцид Монгол Улсын оролцох боломж ба бэрхшээл”. УБ, 2008, №2
47. С.Дашцэвэл. Монгол-АСЕАН-ы хамтын ажиллагаа үндэсний аюулгүй байдалд холбогдох нь. “Монгол улсын үндэсний аюулгүй байдал ба гурав дахь түншийн асуудал” /ред. С.Дашцэвэл/ УБ 2002 он
48. Ж.Жамъян. Дайны үед Монгол Улсаас Вьетнамд үзүүлсэн тусламж. “Монгол-Вьетнамын хамтын ажиллагаа 50 жилд” УБ 2005 он
49. Н.Ишжамц. Эдүгээгийн Азийн тулгамдсан асуудал. “ДДСА” УБ, 1982 №2
50. Н.Ишжамц. Азийн аюулгүй байдал. “Проблемы Дальнего востока” Москва 1975 №2
51. “Монгол-Вьетнамын харилцаа 50 жилд” /ред. С.Дашцэвэл/ УБ 2005 он
52. Т.Мөнхцэцэг. “Юань улсын гадаад харилцаа Монголын Юань улс” /ред. Ч.Дашдаваа, Ж.Болдбаатар/ УБ 2006 он
53. Т.Нарангуа. Монгол-Вьетнамын худалдаа эдийн засгийн харилцаа. “Монгол-Вьетнамын харилцаа 50 жилд” УБ, 2005 он
54. Н.Отгонсүрэн. Хятад ба АСЕАН-ы орнуудын чөлөөт худалдааны бүсийн асуудалд. “Олон улс судлал” сэтгүүл УБ, 2004 он №1
55. Ж.Уянга. Монгол Улс ба АСЕАН-ы хамтын ажиллагаа. “Олон улс судлал” сэтгүүл УБ, 2006 он №3
56. Ж.Уянга. АСЕАН түүний эдийн засгийн интеграци: Өнөөгийн чиг хандлага “Олон улс судлал” сэтгүүл УБ, 2003 он №4
57. Г.Төмөрчулуун. Монгол Улс ба Зүүн Ази. “Олон улс судлал” сэтгүүл УБ, 2005 он №4
58. Ш.Сандаг. Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал “ДДСА” УБ, 1988 №1
59. Ч.Сувд. Зүүн Өмнөд Азийн орнууд хоршин хөгжсөн нь. “ДДСА” УБ, 1992 №2
60. Ч.Сувд. Малайзын хөгжлийн тоймоос. “ДДСА” УБ, 1991 №3
61. Ч.Сувд. Шинээр аж үйлдвэржсэн Азийн орнуудын асуудал. “ДДСА” 1990, №1
62. Ч.Сувд. АСЕАН-ы орнуудын үйлдвэржилтийн асуудал. “ДДСА” 1989
63. Ч.Сувд. Зүүн Өмнөд Азийн холбооны орнуудын эдийн засаг. “ДДСА” 1988 №2
64. Ч.Сувд. Хятадаас Энэтхэг-Хятадын хойгт явуулж буй бодлого. “ДДСА” УБ, 1985 №1

65. “Өнөөгийн Ази: дайн энхийн асуудал” /ред. Ш.Сандаг, С.Дашцэвэл/ УБ, 1989
66. Э.Пунцаг, Ч.Сувд. Хятадаас Зүүн Өмнөд Азид явуулж буй бодлого: Эрт эдүгээд. “ДДСА” УБ 1984, №1
67. Л.Хайсандай. БНМАУ хөгжиж байгаа орнууд. Общественного науки 1998
68. Л.Хайсандай. “Хөгжлийн капиталист биш зам”. УБ 1984 он
69. Б.Хулан. АСЕАН-ы хүрээнд Сингапурын эдийн засаг. “Олон улс судлал” сэтгүүл УБ, 2006 он №3
70. Б.Хулан. Монгол-Сингапурын харилцаа. “Олон улс судлал”, УБ, 2005, №4
71. А.Цолмон. Монгол-Вьетнамын хамтын ажиллагааны ойрын ирээдүй, хэтийн төлөв. “Монгол-Вьетнамын харилцаа 50 жилд”. УБ, 2005 он
72. Б.Цэнгэллхам. “Монгол-Вьетнам ярианы дэвтэр”. УБ, 2008
73. Д.Шүрхүү. “Тайланд орныг сэргээн мандуулсан ван”, “ДДСА” УБ, 1991 он

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Ngo Si Lien, Dai Viet su ky toan thu, q .I, Hanoi, 1967. tr.289
2. Бүтээлийн жагсаалтаас харна уу
3. “Өнөөгийн Ази: дайн энхийн асуудал” (Ред.Ш.Сандаг) УБ.1989 он.
4. Ч.Сувд, Х.Дашдондов, Л.Бэгзжав нарын судалгааг үзнэ үү
5. “Ази тив, түүний салбар бүс нутгуудын хамтын ажиллагаанд Монгол Улсын оролцоо хэтийн төлөв. (Ред. Ц.Батбаяр, С.Дашцэвэл), УБ.1997 он.
6. С.Дашцэвэл. Зүүн Өмнөд Азийн хөгжлийн хандлага, интеграци: Монгол Улсын бодлого чиглэл. УБ, 2005 он “Монгол-Вьетнамын харилцаа 50 жил”. УБ, 2005 он
7. “Монгол Улсын түүх” 5 боть. Дэд дэвтэр. УБ 2004 он 191-204-р тал, “Монголын эзэнт гүрний гадаад харилцаа” (редактор Н.Ишжамц, С.Дашцэвэл) УБ 1995 он, 88-98-р тал, “Монголын Юань улс”. УБ, 2006 он 150-167 тал